


## ЦУ № 02(13)

### Цаг уур, агаарын бохирдол


Зураг 1.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр 2010 оны 2 дугаар сард хамгийн их тунадас (14.4 мм) Ховд аймгийн Булган суманд орсон байна. Энэ сард агаарын хамгийн их температур Өмнөговь аймгийн Ханбогд суманд 13.2 хэм дулаан, хамгийн бага температур Увс аймгийн Тэс суманд -50.0 хэм хүйтэн, цасан бүрхүүлийн хамгийн их зузаан Төв аймгийн Угтаал суманд 103 см байжээ. Салхины хамгийн их хурд Говь-Алтай аймгийн Тонхил сум, Өмнөговь аймгийн Булган суманд 34 м/сек хүрсэн байна.

Азотын давхар ислийн агууламж 2010 оны 2 дугаар сард Улаанбаатар хотын 1-р хороолол орчимд 13 удаа, 13-р хороолол орчимд 19 удаа, 32-ын тойрог орчимд 15 удаа, Офицеруудын ордон орчимд 18 удаа, Дархан-Уул аймгийн Дархан суманд 1 удаа, хүхэрлэг хийн агууламж Хан-Уул дүүрэг орчимд 24 удаа, 1-р хороолол орчимд 18 удаа, 13-р хороолол орчимд 25 удаа, 32-ын тойрог орчимд 17 удаа, Офицеруудын ордон орчимд 21 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 1-р хороололд 27 удаа, 13-р хороололд 22 удаа, Дархан-Уул аймгийн Дархан суманд 27 удаа тус тус агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.



Зураг 2.



Хүснэгт 1.

### Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2010 оны эхний 2 сард 563 удаа гарсны улмаас 53 хүн амь насаа алдаж, 2.9 сая мал хорогджээ. Аюулт үзэгдэл, ослыг төрлөөр нь авч үзвэл объектын түймэр 522 удаа, хүчтэй цасан болон шороон шуурга 8 удаа, газар хөдлөлт 2 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 157.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

### Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний 2 сарын байдлаар\*

Үзүүлэлт	2008 II	2009 I-II	2010 I-II	2010 I-II / 2009 I-II %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	472	421	563	133.7
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо	44	20	53	265.0
Шатсан гэр, орон сууцны тоо	190	125	336	268.8
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, амьтан, мян.тол	5.5	0.6	2 924.1	4746.9 **
Объектын түймрийн тоо	448	406	522	128.6

Тайлбар: \*-Онцгой байдлын ерөнхий газрын мэдээ

\*\* - Дахин их